

ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ АГЕНТЛАГ (ЖАЙКА)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ (ДБХЯ)

МОНГОЛ УЛСЫН

АЛТАЙ ХОТЫН

ГАЗРЫН ДООРХИ УСНЫ

АШИГЛАЛТ - ХӨГЖЛИЙН

СУДАЛГАА

ЭЦСИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

JICA LIBRARY



J 1150482 (6)

1999 ОНЫ 3 - Р САР

Номхон далайн орнуудын олон улсын зөвлөх ХК
(PACIFIC CONSULTANTS INTERNATIONAL)

Эрдсийн хөгжил-Инженерийн "Мицуй"
(MITSUI MINERAL DEVELOPMENT ENGINEERING CO. LTD.)

МОНГОЛ УЛСЫН АЛТАЙ ХОТЫН ГАЗРЫН ДООРХИ УСНЫ
АШИГЛАЛТ - ХӨГЖЛИЙН СУДАЛГАА

ЭЦСИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ
1999 ОНЫ 3 - Р САР

JICA
115
618
SSS
RARY

SSS
JR
99-059

ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ АГЕНТЛАГ (ЖАЙКА)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ (ДБХЯ)

**МОНГОЛ УЛСЫН
АЛТАЙ ХОТЫН
ГАЗРЫН ДООРХИ УСНЫ
АШИГЛАЛТ – ХӨГЖЛИЙН
СУДАЛГАА**

ЭЦСИЙН ТАЙЛАНГИЙН

ХУРААНГУЙ

1999 ОНЫ 3 – Р САР

Номхон далайн орнуудын олон улсын зөвлөх ХК
(PACIFIC CONSULTANTS INTERNATIONAL)

Эрдсийн хөгжил-Инженерийн "Мицүй"
(MITSUI MINERAL DEVELOPMENT ENGINEERING CO., LTD.)

Тайланд бүх ажил үйлчилгээний зардлыг 1998 оны 12 сарын мөнгөн гүйлгээний ханшаар 1 долларыг=890 (1 Долл=117.5 эн) төгрөгөөр тооцов.



1150482 [6]

АГУУЛГА

1. Оршил.....	1
2. ОДООГИЙН БАЙДАЛ	
2.1 Нийгмийн сектор ба эрүүл ахуйн байдал	1
2.2 Алтай хотын эдийн засаг	3
2.3 Цаг уур ба ус зүй.....	4
2.4 Топографи ба геологи.....	6
2.5 Гидрогеологи.....	6
2.6 Экологи ба хүрээлэн байгаа орчин.....	9
2.7 Усны чанар.....	11
2.8 Ус хангамжийн систем.....	12
3. МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ СУДАЛГАА	
3.1 Усны нөөц.....	14
3.2 Хүн ам ба усны хэрэгцээний хэтийн төлөв	15
3.3 Ашиглалтын төлөвлөгөө	17
3.4 Үйл ажиллагаа, засвар үйлчилгээний төлөвлөгөө	21
3.5 Мониторингийн төлөвлөгөө	24
3.6 Зардлын тооцоо	25
3.7 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх.....	26
3.8 Ариун цэврийг сайжруулах хөтөлбөр.....	27
3.9 Мастер төлөвлөгөөнд төслийн үнэлгээ хийх.....	27
3.10 ТЭЗҮ боловсруулахад хэрэгжүүлэх төслийн тэргүүлэх байдлыг сонгох.....	31

4. ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ (ТЭЗҮ)	
4.1 Зураг төслийн нөхцөл	32
4.2 Хөгжлийн төлөвлөгөө	32
4.3 Үйл ажиллагаа, засвар үйлчилгээний төлөвлөгөө	33
4.4 Мониторингийн төлөвлөгөө	33
4.5 Зардлийн тооцоо	34
4.6 Хэрэгжүүлэх хуваарь	35
4.7 Төлбөрийн төлөвлөгөө	36
4.8 Үйл ажиллагаа, засвар үйлчилгээний зардал	37
4.9 Ариун цэврийг сайжруулах хөтөлбөр	38
4.10 Төслийн үнэлгээ хийх	38
4.11 Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБУ)	40
5. Дүгнэлт ба гарах зөвлөмжүүд	41

Хүснэгт ба зургийн агуулга

Хүснэгт 1	Цооногуудын өрөмдлөгийн мэдээ	44
Хүснэгт 2	Ус хангамжийн системийн усны чанар	45
Зураг 1	Усны эх үүсвэрүүдийн байршил	46
Зураг 2	Ус зүйн стсанцын байршил	47
Зураг 3	Судалгааны талбайн геологийн зураг	48
Зураг 4	Геологийн зүсэлт	49
Зураг 5	Газрын доорхи усны түвшин	50
Зураг 6	Судалгааны талбайн гидрогеологийн зураг	51
Зураг 7	Алтай хотын ус хангамжийн систем	52
Зураг 8	2015 оны ус хангамжийн сүлжээний систем	53
Зураг 9	Алтай хотын хөгжлийн өсөлт	54

1. ОРШИЛ

Уг судалгааны судлах зүйлс нь:

- 1 усны нөөцийн (газрын доорхи ус) ашиглалтын Мастер төлөвлөгөө болон 2015 он хүртэл Алтай хотын усан хангамжийн системийг сайжруулах төлөвлөгөө боловсруулах.
- 2 2005 он хүртэл Мастер төлөвлөгөөнд заагдсан тэргүүлэх төслийн ТЭЗҮ судалгаа явуулах.
- 3 судалгааний явцад хамтран ажиллагсад технологий даамжуулах.

Судалгааны талбай нь нийт 600 км² орчим газрыг хамарна. Газрын доорхи усны нарийвчилсан судалгааг Харзат болон Сүхийн хоолойд явууллаа. Завхан голын дагуух Цагаантохой, Тайширыг урьдах судалгааны үр дүнгээр усны боломжит нэмэгдэл эх үүсвэрээр авч судлав. Зураг 1 -д судалгааны талбайг харуулсан болно.

2. ОДООГИЙН БАЙДАЛ

2.1. НИЙГМИЙН СЕКТОР БА ЭРҮҮЛ АХУЙН БОЛОВСРОЛ

(1) Нийгмийн байдал

Алтай хотын хүн ам нь соёлын болон хэлний хувьд нэг бөгөөд усны үнийн төлбөрийн зөрүүг үл тооцвол хүн амын дотор том ялгаа байхгүй.

- Жилийн нийт дундаж орлого : 299 940 т (сард :24 995 т)
- Сарын нийт дундаж зарлага : 44 500 т (гэр) - 58810 т (орон сууц)
- Усны төлбөр нийт орлогоос : орон сууцны оршин суугчдаас 1 хувь, гэр хороололд 2 хувь.
- Гэр хорооллын оршин суугчдын ус зөөдөг зай : 200 м дотор 70 хувьд нь
- Хүмүүс ундны усны эрдэсжилтийг бууруулах арга, хэрэгслийг нэвтрүүлэх сонирхолтой.

(2) Усны чанар ба эрүүл мэнд

Алтай хотын хүмүүсийн 60 орчим хувь нь ундны усны чанар муу гэж үздэг байна. Тэдний бодлоор усны хатуулаг нь өвчлөлт авчирдаг. Мөн түүнчлэн зарим дээгүүр албан тушаалтнууд кальци, магнийн харьцаа алдагдсан, агуулга өндөр байгаа нь нас баралтын тоог нэмэгдүүлэхэд нөлөөлдөг гэдэг юм байна.

Судалгааны хэсгээс явуулсан усны шинжилгээний үр дүнгээр усны химийн найрлагын ихэнх элементүүд, хатуулаг нь Монголын ундны усны стандартын хэмжээнд байгаа юм.

Магнийн агуулга нь Монголын стандартынхаас яльгүй өндөр байгаа боловч Япон болон бусад ихэнх орны стандартад магнийн агуулга тийм хэмжээнд байх ёстой гэж заадаггүйг доорхи хүснэгтээс харж болно.

Усны хатуулаг болон кальци, магнийн агуулгын хэмжээг усны чанарын стандарт, гарын авлагуудад хязгаарласан байдал.

Стандарт/гарын авлага/	Нийт хатуулаг	Кальци	Магни
Судалгааны үр дүн(ус хангамжийн)	199 мгCaCO ₃ /л	28 мг/л	31 мг/л
Монголын стандарт	7 мг экв/л (350 мг CaCO ₃ /л)	100 мг/л	30 мг/л
Европын холбоо (1995)	-	-	-
ДЭМБ (эрүүл мэндийн)	-	-	-
ДЭМБ (байж болох)	500 мг CaCO ₃ /л	-	-
Японы стандарт	300 мг CaCO ₃ /л	-	-
АНУ -ын стандарт	-	-	-
Болгарын стандарт	600 мг CaCO ₃ /л	150 мг/л	80 мг/л

- тогтоосон хязгаар байхгүй

Архаг өвчнүүдийн шууд нөлөөллийг тодорхойлоход халдваргүй өвчнүүд нь тамхи татах, архи уух, удамшил, нас, хүйс, хоол ундны зуршил зэрэг маш олон эрсдэлийн хүчин зүйлүүдээс хамаардаг учраас усны чанараас шалтгаалж байгаа эсэхийг тогтооход бэрхшээлтэй байдаг.

(3) Эрүүл ахуйн боловсрол

1998 оны 10 дугаар сарын 31- ны байдлаар Говь -Алтай аймгийн Нийгмийн эрүүл мэндийн төвөөс сургуулийн багш болон эрүүл мэндийн сайн дурынханд сургагчдын сургалтыг 7 удаа, эрүүл ахуйн сургалтыг эхчүүд болон хүүхдүүдэд 6 удаа судалгааны хэсгээс бэлтгэсэн номыг ашиглан зохион явуулжээ. Үүнд нийт 909 хүн хамрагдсан.

(4) Нийгмийн дүн шинжилгээ

Цаашдын төлөвлөгөө/төслийн ашигтай(+) болон ашиггүй байдал(-)

- Гэр хорооллын оршин суугчдын өндөр орлоготой хэсэг нь одоогийн усны тарифийг 161 %, доогуур орлоготой нь 80% нэмэгдүүлэхийг дэмжиж байна.
- + Ус түгээх байруудыг байгуулах нь усаар хангагдах байдлыг хугацаа болон зайн хувьд сайжруулна. Ингэснээр усыг гэрт удаанаар хадгалах зуршил, түүнээс үүсэх бохирдлыг багасгах боломжтой.
- Гэрийн оршин суугчдын 20% нь цаашид ч 250 м радиусаас ус авах боломжгүй.

Усны тариф

Гэр хорооллын болон орон сууцны оршин суугчдын усны үнийн төлбөрийн зөрөөтэй байдал нь олон нийтэд баримтыг ил тод болгосноор өөрчлөгдөнө.

2.2 АЛТАЙ ХОТЫН ЭДИЙН ЗАСАГ

(1) Хүн ам

Алтай хотын хүн амын тоог доорхи хүснэгтэд нэгтгэн үзүүлэв.

Он	Хүн ам
1995	20 068
1996	17 121
1997	17 761

1996 онд хүн амын тоо буурсан нь (14,7%) хүн амын гадагш шилжилт болон хүн амын дахин тооллого хийсэн 2 хүчин зүйлээс шалтгаална.

(2) Эдийн засаг

Монголын дотоодын нийт бүтээгдэхүүнээр мэдээ материал бэлтгэгдээгүй. Алтай хотын эдийн засгийг статистикийн болон бусад төрөл бүрийн мэдээллүүдийг нэгтгэх замаар шинжлэн судаллаа.

- 1 Тоон мэдээнээс харахад 1996, 1997, 1998 онд малын тоо өсчээ.
- 2 Үр тарианы үйлдвэрлэлийн хэмжээ 1996 оноос нэмэгдэх хандлагатай байна.
- 3 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн ба борлуулалт нь байнга буурах хандлагатай байна.
- 4 Ачаа тээвэрлэлт 1995 оноос бага хэмжээгээр өсч байгаа нь байнгын худалдаа наймааны үйл ажиллагаатай холбоотой байж болох юм.

5 Үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн нилээд буурчээ. 1990 оны эхнээс 7 төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл зогссон байна.

ХАА- н секторын бүтэц, ялангуяа мал аж ахуй голлох ёстой. Говь- Алтай аймаг нь малын тоогоороо Монголд эхний 4- т ордог учраас ХАА- н сектор нь гүйцэтгэх үүргээрээ аймгийн эдийн засагт 50 хувиас илүү байна. Хэдийгээр аж үйлдвэрийн бүтээгдэхүүн буурч байгаа ч Алтай хотын эдийн засаг нь ХАА-н сектор, үүнтэй холбоотой үйл ажиллагааны дэмжлэгтэйгээр тогтворжих буюу бага багаар хөгжих боломжтой. Том хэмжээний болон уламжлалт үйлдвэрлэл зогсонги байдалд байгаа буюу буурч байгаа бөгөөд ахуйн жижиг хэмжээний үйл ажиллагаанууд нэмэгдэж байна.

Хамгийн том асуудал бол ажиллах хүчний дутагдал болон орон нутгийн банкны зээлийн хүү маш өндөр, тухайлбал сард 10% буюу жилд 214% байдаг явдал юм.

2.3. Цаг уур ба ус зүй

(1) Цаг уур

Цаг уур ба ус зүйн станцуудыг Зураг 2 -т харуулав.

Хур тунадас

Алтайн сав газарт голлох хур тунадас 6 - 8 сард унадаг бөгөөд үүний нийлбэр нь доорхи хүснэгтэд тооцоолсноор жилийн нийт хур тунадасны 64 орчим хувийг эзэлдэг.

Станц	Сарын дундаж хур тунадас (мм)												Нийт (мм)
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Алтай	1,1	2,1	5,8	10,5	13,2	29,2	48,2	41,8	17,1	7,3	3,1	2,2	181,6
Хантай шир	1,1	2,3	7,3	10,8	13,8	31,5	39,1	55,4	22,4	11,1	4,0	1,6	200,4

Алтай хот станцын мэдээ 1955 оноос 1996 оны 8 сар; Хан Тайширынх 1978 - 1989 он хүртэл.

ЖАЙКА- гийн судалгаа

Ууршилт ба хур тунадасны хэмжилтийн үр дүнг доорхи хүснэгтэд үзүүлэв.

Сарын ууршилт ба хур тунадас (мм)

	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Ууршилт												
1997	-	-	-	-	-	-	238,7	179,2	136,2	-	-	-
1998	-	-	-	-	182,2	217,0	166,5	146,5	136,1	68,1	-	-
Хур тунадас												
1997	-	-	-	-	-	-	83,7	1,2	11,6	-	-	-
1998	-	-	-	-	15,9	10,6	113,7	13,1	7,1	-	-	-

1997, 1998 оны 7 сард харьцангуй их хэмжээний бороо орсон.

(2) Гидрологийн үзүүлэлтүүд

Гуулин ба Дөрвөлжингийн станцын орчим Завхан голын усны жилийн дундаж урсацын хэмжээг тооцоолоход ойролцоогоор тус тус 299 (9,49м³/с) ба 447 (14,17м³/с) сая м³ байлаа. Жилийн нийт урсацын 52 орчим хувь нь 6 - 8 сарын хур тунадасны улиралд хамрагдана.

Судалгааны талбайн жижиг голуудын голын өнгөрөлт

ЖАЙКА- гийн судалгааны хэсгээс голын өнгөрөлтийг судалгааны талбайн 4 гол: Хадаасангийн ам, Мандалын арын, Естийн сайр, Хангинаагийн хоолойн голуудад хийлээ. Эдгээр нь ерөнхийдөө урсгал үсгүй. Зөвхөн их хэмжээний борооны дараа зарим сайранд урсац бий болдог.

2.4. ТОПОГРАФИ БА ГЕОЛОГИ

Алтай хот нь Алтайн нурууны ар бэлийн хойд хэсэгт 2040 - 2180 м өндөрт оршдог.

Дөрөвдөгчийн настай зөөгдлийн хурдас нь Алтай хотын өмнөд хэсгээр тархсан бөгөөд эдгээр хурдсан дахь түрэлтгүй уст үеийг Алтай хотын унд ахуйн хэрэглээний усны эх үүсвэр болгон ашигладаг.

Неогений шаварлаг хурдас нь судалгааны талбайд дөрөвдөгчийн зөөгдлийн хурдасны доор тархсан. Энэ хурдас нь ус нэвчүүлдэггүй.

Үндсэн чулуулгууд нь Алтайн нуруунд Кембрийн өмнөх хэт суурилаг чулуулгууд: перидотит, серпентинит, Алтай хотын хойд хэсгээр Кембрийн өмнөх гнейсс, кварцит, занараас тогтдог. (Зураг 3, 4).

Хагарал, ан цавын бүсүүд нь үндсэн чулуулгуудад зүүнээс баруун, баруун хойноос зүүн урагш чиглэлээр тархсан бөгөөд хагарлын бүсийн зарим хэсэг нь ан цавын усыг агуулна.

2.5. ГИДРОГЕОЛОГИ

ЖАЙКА -гийн туршилтын цооногуудын үр дүнг Хүснэгт 1 -д нэгтгэн харуулав.

(1) Газрын доорхи усны түвшин

Ажиглалтын цооногуудад газрын доорхи усны түвшний хэмжилтийг 1997 оны 6 сараас 1998 оны 10 сар хүртэл хийлээ.

Ажиглалтын цооногууд нь доорхи 3 группт хуваагдана: А (гүн цооногууд), В (гүехэн цооногууд), С (Сүхийн хоолойн гүехэн цооногууд).

В, С группийн цооногуудын усны түвшин нь хур тунадасны улирлын эцэс буюу 1997, 1998 оны 7 сараас доошилж эхэлнэ. Гэтэл А группийн түвшин нь 10 сарын эцэс хүртэл дээшилж байна. 2 сарын эхнээс В группийн цооногийн усны түвшин нь дээшилсээр байхад А группынх нь 4 сарын дунд хүртэл доошилсоор байна.

(2) Гидрогеологийн үзүүлэлтүүд

Дөрөвдөгчийн уст үе

Усны эх үүсвэр	Хувийн ундарга (м ³ /хон/м)	Шүүрэлтийн К (м/хон)	Түвшин дамжуулалт (м ³ /хон/м)*1	Шавхалтын ундарга (л/сек)
Харзат	1 - 864	0,07 - 9,4	157 - 565 (дундаж 360)	0,01 - 12,4 (дундаж 3,15)
Олон нуур	1 - 93	0,1 - 16,3		1,2 - 7,1 (дундаж 2,51)
Сүхийн хоолой*2	187 хамгийн их	4,57-8,3 хамгийн их		0,18 - 10,6 (дундаж 3,59)

*1 : хувийн ундаргаас тооцоолсон

*2 : усны эх үүсвэрт хангалтгүй нөөцтэй. Хязгаарлагдмал жижиг талбайд тархсан.

Олон нуурт өрөмдсөн ЖАЙКА - гийн туршилтын цооног В - 6 гийн түвшин дамжуулалт нь 1000 м³/хон/м ба хатуулаг нь 257,7 мгСаСО₃/л. Энэ нь усан хангамжинд ашиглахад маш тохиромжтой. Харзат, Олон нуурын зааг дээр өрөмдсөн В - 5 цооног нь усан хангамжинд дунд зэргийн ач холбогдолтой ба түвшин дамжуулалт нь 39 м³/хон/м ба хатуулаг нь 225 мгСаСО₃/л байна.

Алтай хотын зүүн хойно орших бусад В - 1, В - 4 цооногуудын түвшин дамжуулалт нь 1,3 - 5,1 м³/хон/м ба хатуулаг нь 845 - 1950 мгСаСО₃/л. Эдгээр цооногууд нь усны нөөц, чанарын хувьд төвлөрсөн усан хангамжинд тохиромжгүй.

Неогений уст үе

Неогений уст үе нь Харзат, Олон нуур, Сүхийн хоолойн дөрөвдөгчийн уст үеийн доор оршино. Энэ уст үе нь Сүхийн хоолойд өргөн тархсан.

Өмнөх тайлангуудад бичсэнээр эдгээрийн шавхалтын ундарга нь 0,2 - 0,4 л/сек тул Неогений уст үе нь усан хангамжинд тохиромжгүй.

Ан цавын уст үе

Өмнөх судалгаануудаар энэ уст үеийн шавхалтын ундарга нь 1,6 - 14,4 л/сек болох нь тогтоогдсон. Алтай хотын зүүн хойно өрөмдсөн ЖАЙКА - гийн туршилтын цооног А-3 ын шавхалтын ундарга нь 16 л/сек орчим, түвшин дамжуулалт нь 200 м³/хон/м байв. Энэ нь усны нөөцийн хувьд сайн боловч хатуулаг нь 1875 мгСаСО₃/л хүрдэг.

Цооног А-1 ийн түвшин дамжуулалт нь $1,3 \text{ м}^3/\text{хон}/\text{м}$ (хатуулаг: $1000 \text{ мгCaCO}_3/\text{л}$), А-2 ынх нь $10,4 \text{ м}^3/\text{хон}/\text{м}$ (хатуулаг: $372,5 \text{ мгCaCO}_3/\text{л}$), А-3 ынх нь $7,4 \text{ м}^3/\text{хон}/\text{м}$ (хатуулаг: $362,5 \text{ мгCaCO}_3/\text{л}$) байна.

(2) Газрын доорхи усны нөөц

Судалгааны талбайд доорхи усны эх үүсвэрүүд байгаа ба тэдгээрийг ашиглах боломжийг дурьдвал: (Зураг 1).

- 1 Харзатын эх үүсвэрийг : өргөжүүлэх боломжтой өргөжүүлэх
- 2 Олон нуурын эх үүсвэрийг : ашиглах боломжтой ашиглах
- 3 Сүхийн хоолойн эх : усны чанар муу үүсвэрийг ашиглах
- 4 Хадаасангийн эх үүсвэрийг : хангалттай нөөцтэй. ашиглах
- 5 Алтай хотын зүүн хойт хэсгийн эх үүсвэрийг : Усны нөөц дунд зэрэг. ашиглах
- 6 Цагаан тохойн эх үүсвэрийг : хангалттай нөөцтэй, усны чанар боломжтой, гэвч маш хол зайтай (98 км) бөгөөд хэтэрхий нам газар (Алтайгаас - 280 м доор)
- 7 Тайшираас Завхан голын усыг ашиглах : хангалттай нөөцтэй, гэвч маш хол зайтай (45 км) бөгөөд хэтэрхий нам газар (Алтайгаас - 470 м доор) учраас 5 - 6 туслах насос шаардлагатай.

Эндээс Харзатын усны эх үүсвэрийг эхний ээлжинд ашиглах боломжтой гэж дүгнэв.

(4) Харзатын усны эх үүсвэрийн нөөц баялаг

Газрын доорхи усны геологийн нөөц

Газрын доорхи усны геологийн нөөцийг $0,1 - 0,15$ ус өгөмжийн коэффициентоор тооцоолоход хамгийн бага нь $26,9 \times 10^6 \text{ м}^3$, хамгийн их нь $40,3 \times 10^6 \text{ м}^3$ гарч байна.

(5) Газрын доорхи усны тэнцэл

Гадаргын болон газрын доорхи усны тэнцлийг дараах томъёогоор тодорхойлов.

*Хур тунадас = Ууршилт+гадагш урсац+гүн рүү нэвчилт
(= Дотоод урсац+тэжээгдлийн хэмжээ+суурь урсац)

*Газрын доорхи усны чадавхи = Тэжээгдлийн хэмжээ-ашиглалтын хэмжээ-суурь урсац (=Ойролцоогоор 0)

Тэжээгдлийн хэмжээ

Харзатын уст үеийн тэжээгдлийн хэмжээг доор тооцоолов.

Уст үеийн тэжээгдлийн хэмжээ

Талбай	Ус цуглуулах Талбай	Жилийн хур тунадас	8 мм/хон-оос их	Тэжээх хур тунадас	Тэжээх хэмжээ
Харзат	70 км ² орчим	181,1 мм	34,4 мм	25,4 мм/жил (нийтээ с 14%)	4 870 м ³ /хон 1 778 000м ³ /жил

Усны түвшингийн удаан хугацааны горимын хэмжилтийн үр дүнд хур тундасны хэмжээ 8 мм/хоногоос дээш бол усны түвшинд нөлөөлдөг болох нь тогтоогдсон. Жилийн хур тунадасны 16 хувь нь газрын гүнд нэвчих боломжтой. Түүний 2 хувь нь гүний усны түвшинд хүрэлгүйгээр өнгөн хөрсний завсраар хэвтээ урсац үүсгэж болох юм.

11 сараас 4 сарын дунд хүртэлх өвлийн улиралд ямар ч тэжээгдэл байхгүй.

Газрын доорхи усны ашиглалт

Харзатын ус татах худгуудын нийт ундарга нь дунджаар 960 м³/хон, хамгийн их нь 1150 м³/хон юм.

2.6 ЭКОЛОГИ БА ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧИН

(1) Алтай хотын экологи

Амьтан

Судалгааны талбайд зарим сүүн тэжээлтнүүд ажиглагдах хэдий ч Алтай хотын хөгжилт нь том сүүн тэжээлт амьтны тархалтыг багасгаж байна. Энд элбэг тохиолдох сүүн тэжээлтнүүд нь үлийн цагаан оготно, чандага, Сибирийн тарвага, улаан үнэг, хярс, элбэг тохиолдох шувуунууд нь адууч чогчоохой, умардын дууч шувуу, хээрийн бор шувуу, хөх цэгцгий, шоорон алаг болжмор, хон хэрээ, хөхвөр тагтаа болно. Хадаасангийн голын орчимд шувууны олон төрөл ажиглагдсан. Хавар, зуны чийглэг улиралд усны

шувууд нуур, голын усанд түр буудалладаг. Элбэг тохиолдох шавьжнууд нь хуурай тал газрын дэвхрэг, царцаанууд юм.

Ургамал

Алтай хотын орчмын их хэмжээний газрыг бэлчээрт ашигладаг. Хот орчмын газрын бэлчээрийн ачаалал хэт их байгаа болон өнөөгийн замбараагүй, олон салаалсан замууд нь хөрс болон ургамлыг эвдрэлд оруулж байна. Алтай хот орчмын ургамал нь "Хуурай целийн" ба "Цөл талын" гэсэн 2 төрөлд хуваагдана.

(2) Хууль тогтоомж

Монгол улсад хүрээлэн байгаа орчны талаар 20 гаруй хууль, тогтоомж байдаг. Мөн түүнчлэн Монгол улс нь хүрээлэн байгаа орчны олон улсын гэрээ, конвенцид оролцдог.

(3) Гүйцэтгэгч агентлаг

Байгаль Орчны Яам (БОЯ) нь байгалийн болон нийгмийн хүрээлэн байгаа орчныг судлах, хянах, хамгаалах үүрэгтэй.

(4) Байгаль орчны унаган төрхийн үнэлгээ (БОУТУ)

Монгол улсад БОУТУ -г Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ байдлаар Монгол улсын Их Хурлаар 1998 оны 1 сарын 22 -нд батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу явуулна. Тухайн төсөлд уг үнэлгээг 1998 оны 5 сарын 22 -нд БОЯ -ны Бодлого зохицуулалтын газрын улсын хяналтын ахлах байцаагч хийсэн.

(5) Монголын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

Доорхи хуулиуд нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБУ) - ний нөхцөлийг бүрдүүлнэ.

" Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль" (1998 оны 2 сарын 20- ноос хүчин төгөлдөр болсон), Хавсралт, Хавсралт 1, Хавсралт 2.

БОЯ болон орон нутгийн ЗДТГ ерөнхий үнэлгээг хийх бөгөөд БОНБУ- ний шаардлагатай түвшинг доорхи байдлаар сонгоно.

-БОНБУ-ний цаашдын судалгаа шаардлагагүй.
-БОНБУ-ний тодорхой үзүүлэлтийн судалгаа шаардлагатай.
-БОНБУ- ний бүх шатны судалгаа шаардлагатай.

Хэрэв шаардлагатай бол тухайн төсөлд БОНБУ- ний судалгааг эрх бүхий байгууллага ЗДТГ- ын хяналтан дор явуулна. БОНБУ-ний судалгааны үр дүнг олон нийтэд ил мэдээллэнэ. ЗДТГ нь судалгаанд үндэслэн уг төслийг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.

2.7 УСНЫ ЧАНАР

Дээжлэлт хийсэн газар

Одоо ажиллаж байгаа худаг : SW - 6, SW - 8. (1998 5 сарын 30)

Ус хангамжийн систем : DR - 1, DR - 2, DT - 1, DT - 2, DT -3, DT -4, DT -5, DW- 1, DW - 2

(Зураг 10) .

Шинэ туршилтын цооног : A1, A2, A3, A4, B1, B2, B3, B4, B5, B6.

Худгуудын усны чанар

Одоо ажиллаж байгаа худгуудын SW - 6 аас бусдынх нь усны хатуулаг, магни, сульфатын агуулга өндөр учраас ундаанд тохиромжгүй.

Шинээр ерөмдсөн туршилтын цооногуудын хувьд B- 5, B- 6 гаас бусад нь усны хатуулаг, магни, сульфатын хэмжээ өндөр байгаа учир ундны усанд хэрэглэх боломжгүй.

Ус хангамжийн системийн усны чанар

Магнийн агуулга нь Монголын ундны усны стандартаас ялимгүй өндөр байна. Усан сан, крантны ус, усны машин, гэрт хадгалж байгаа усанд нийт колиформын хэмжээ стандартын хэмжээнээс өндөр байна. Бусад үзүүлэлтүүд нь стандартын хэмжээнд тохирч байгаа юм (Хүснэгт 2 -ыг үз).

2.8 УС ХАНГАМЖИЙН СИСТЕМ

(1) Ус хангамжийн үйлчилгээний байдал

Үйлчлэх талбай

Ундны усыг хотын төв хэсэгт (орон сууцны байрууд; ойролцоогоор 120 га) шугамын сүлжээгээр, гэр хороололд ус зөөврийн машинаар түгээдэг.

Үйлчилгээнд хамрагдах хүн ам

Категори	Хүн ам	Өрхийн тоо	Өрхийн хэмжээ
Орон сууцны суугчид	3245	488	6,6
Гэр хорооллын	14516	2661	5,5
Нийт	17761	3419	5,6

(2) Одоогийн ус хангамжийн систем

Ус хангамжийн системийн үйл ажиллагааг Алтай хотын НААҮГ хариуцан явуулдаг. НААҮГ нь 8 халаалтын зуухыг усаар хангах үүрэгтэй (халаалтын зуух хүйтний улиралд төвийн хэсгийг халуун усаар хангадаг). Гэр хороололд усыг өдөр бүр 4 м^3 - $4,75 \text{ м}^3$ эзэлхүүнтэй 4 ус зөөврийн машинаар хүргэдэг. Ус хангамжийн системийг Зураг 7 -д нэгтгэн үзүүлэв.

Усан хангамжийн тоног төхөөрөмж ба хүчин чадал (1998 оны 10 сар)

Олзворлох худгууд	1200 м^3 /хон	25 м^3 /ц х 24ц х 4ш (1979,1986,1995)-2 ыг нь ашигладаг, 1 нь нөөцөнд, 1 нь засварт
Дамжуулах шугам	-	Диа.150 ммх2шугам, 3,4км х 2 =6,8 км
Усан сан	2000 м^3	1000 м^3 х 2 сан
Түгээх насос	180 м^3 /цаг	90 м^3 /ц х 24ц х 3ш (1 нь нөөцөнд)
Түгээх шугам	-	Диа.200мм х 5600м + диа.125 мм х 135м, ган шугамууд
Усны машин	Хамгийн их 78 м^3 /цаг	4 машин (4 м^3 х 3машин +4,75 м^3 х 1машин)

(3) Ус хангамжийн бодит хэмжээ

Ус хэрэглээ өвлийн улиралд зуныхаас 20% орчмоор илүү байдаг. Учир нь өвлийн улиралд халаалтанд ус ихээр шаардагддаг.

Улирал	Хэмжээ (м ³ /хон)	Тэмдэглэл
Зун	860	Шөнө дунд : 6,5 м ³ /цаг (ус алдагдал?)
өвөл	1060	Шөнө дунд : 35 - 38 м ³ /цаг (ус алдагдал?) Хамгийн их : (9.00 - 10.00) (Баасан) (10.00 - 11.00) (Бямба)

Зуны улирал : 5 сарын дундаас 9 сар

Өвлийн улирал : 10 сараас 5 сарын дунд хүртэл

(4) Ус хэрэглээ

Ажуйн хэрэглээ

Оршин суугчид	Сарын хэрэглээ (1997 - 1998) (нэгж : м ³)												Нийт Жилд
	10	11	12	1	2	3	4	5	6	7	8	9	
Орон сууц	4950	4950	4950	5202	5202	5202	5202	5202	5202	5202	5202	5202	61 668
Гэр	940	980	988	1194	1301	1331	1108	1259	1663	1378	1213	1734	15 089

Орон сууц : өдрийн дундаж : 169,0 м³, өдрийн хамгийн их 185,3 м³

Гэр : өдрийн дундаж : 41,3 м³, өдрийн хамгийн их 57,8 м³

Албан байгууллагын хэрэглээ

Категори	Жилийн дундаж хэрэглээ (м ³ /хон)		Сарын хамгийн их хэрэглээ (м ³ /хон)	
	Хэмжээ	Хувиар	Хэмжээ	Хувиар
1. Албан байгууллага	136	93,8%	229	94,2%
Нийтийн халаалтын зуух	(16)	(11)%	(140)	(57,6)%
2. Нийт үйлдвэрүүд	9	6,2%	14	5,8%
БҮГД	145	100%	243	100%

3. МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ СУДАЛГАА

3.1 УСНЫ НӨӨЦ

(1) Газрын доорхи усны нөөцийн үнэлгээ

Доорхи хүснэгтээс үзэхэд Харзатын эх үүсвэр усны нөөц, чанар, эдийн засгийн үзүүлэлтүүдээрээ эхний ээлжинд ашиглагдах боломжтой.

Газрын доорхи усны нөөцийн шалгуурууд

Усны эх Үүсвэр	Уст үеийн төрөл	Зай (км)	Өндөр Шилт (м)	Чадав хи	Усны чанар	Хатуу лаг (мг CaCO ₃ /л)	Барил га бай. өртөг	Үйлчил гээний зарлал	Тэргүү лэх бо ломж
Харзат	AI	4-6	2180	Их	Сайн	225	Бага	Бага	1
Олон нуур	AI	8-9	2190	Их	Сайн	256	Бага	Дунд	2
Сүхийн хоолой	Q	8-10	2050	Дунд	Муу		Дунд	Өндөр	-
Хадаасан	Анцав	6-7	2150	Бага	Дунд	363	Дунд	Өндөр	-
Алтайн ЭХ	Анцав	2-3	2120	Дунд	Муу	1875	Бага	Дунд	-
Цагаантохой	AI	98	1890	Их	Сайн	406	Өндө р	Өндөр	-
Тайшир	AI	45	1700	Их	Сайн	-	Өндө р	Өндөр	-

* - зай (ЗДТГ - аас) өндөршилт 2170 м

(2) Харзатын газрын доорхи усны эх үүсвэрийн чадавхи

Усан хангамжинд зуны улиралд 3000 м³/хоногоос илүү хэмжээний усыг ашиглах боломжтой.

Нийт нөөц = (Геологийн нөөц + тэжээгдлийн хэмжээ) - зарцуулалт
(ашиглалт + суурь урсац)

Харзатын газрын доорхи усны нөөцийн чадавхи (м³/хон)

Усны эх үүсвэр	Боломжит чадавхи	Ашиглах хэмжээ	Боломжит хэмжээ
Харзат	4870	1150	>3000

Усны геологийн нөөцийг (26 900 000м³) усны түвшин, усны чанарын тогтоосон горимоор 11 сараас 4 сар хүртэлх өвлийн улиралд ашиглаж болно.

3.2 Хүн ам ба усны хэрэгцээний хэтийн төлөв

(1) Нийгэм – эдийн засгийн хөгжлийн цар хүрээ

Алтай хотын эдийн засгийн өсөлтийг доор үзүүлэв.

Эдийн засгийн төлөв (хувь/жил)

	1996 – 2005	2005 – 2015
Нийт эдийн засаг	3,0	4,0
Аж үйлдвэр	4,0	5,0

Зураг 9 -д эдийн засгийн өсөлтийн байдлыг үзүүлэв.

(2) Хүн амын хэтийн төлөв

Алтай хотын хүн амын өсөлт

Он	Гэр	Орон сууц	Нийт
1997	14 516	3 245	17 761
2005	15 357	3 433	18 790
2015	17 131	3 830	20 961

(3) Усны хэрэгцээний хэтийн төлөв

Үр дүнг доорхи хүснэгтэд үзүүлэв.

Алтай хотын одоогийн нийт усны хэрэгцээг гаргахдаа ус алдагдлыг оролцуулан тооцоолсон болно. Ус алдагдал нь хоногийн ус хэрэглээний 30 орчим хувийг эзэлж байгаа нь 2005 болон 2015 оны усан хангамжийн байгууламжийг байгуулж дуусгаснаар багасах юм. Ус алдагдлыг 2005 онд 25% 2015 онд 20 % болгохоор зорьж байна.

Усны хэрэгцээний төлөв

	Категори	Хүн ам (тоо)	Үйлчилгээ (%)	Нэгж хэрэгцээ (л/хон) (хамгийн их)	Усны хэрэгцээ (м ³ /хон)		Тайлбар
					дундаж	Хамгийн их	
1997 - 1998	Орон сууц	3 245	100	150	487	487	
	Гэр	14 516	62 (100)	8,6 (5,2)	41	78	
	Албан бай	(31)	-	-	136	229	1998 оны мэдээг үндэслэн
	Үйлдвэр	(3)	-	-	9	14	1998 оны мэдээг үндэслэн
	Алдагдал	-	-	-	287	324	Бүгд -ийн 30%
	Бүгд	17 761			960	1 150	
2005	Орон сууц	3 433	100	150	515	515	
	Гэр	15 357	100	20	163	307	Дундаж = хамгийн их х (41/78) = 0,53 (хамгийн их)
	Албан байгууллага	(38)	-	-	167	282	Жилийн 3% өсөлт
	Үйлдвэр	(4)	-	-	12	19	Жилийн 4% өсөлт
	Алдагдал	-	-	-	283	377	Бүгд -ийн 25%
	Бүгд	18 790			1 140	1 500	
2015	Орон сууц	3 830	100	150	575	575	
	Гэр	17 131	100	40	363	685	
	Албан байгууллага	(56)	-	-	248	417	Жилийн 4% өсөлт
	Үйлдвэр	(7)	-	-	20	31	Жилийн 5% өсөлт
	Алдагдал	-	-	-	294	432	Бүгд -ийн 25%
	Бүгд	20 960			1 500	2 140	

3.3 АШИГЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

(1) Зураг төслийн нөхцөл

Усан хангамжийн үйлчилгээний байгууламжийн зураг төслийн нөхцөлийг доорхи хүснэгтэд үзүүлэв.

Зураг төслийн нөхцөл

Үзүүлэлт	1997	2005 (ТЭЗҮ)	2015 (МТ)
Хүн ам	17 761	18 790	20 961
Үйлчилгээ (%)			
Орон сууц	100	100	100
Гэр хороолол	60-100	100	100
Нэгж ус хэрэглээ (л/хон)			
Орон сууц	150	150	150
Гэр хороолол	8,6	20	40
Ус хангамжийн арга*			
Орон сууц	Шугам/цорго		
Гэр хороолол	Шугам/цорго 1 ус түгээх байр/1000 -1500 хүнд/ 1 ус түгээх байр/250м -ийн радиусд/		
Ус хэрэглээний өсөлт (%/жил)		1998 - 2005	2006 - 2015
Албан байгууллага	-	3	4
Үйлдвэр	-	4	5
Ашигтай усны түвшин (%)	70	75	80
Усны хамгийн их хэрэгцээ (м³/хон-оор)	1 150	1 500	2 140
Усны хамгийн их хэрэгцээ (м³/цагаар)	65	133	205

* : Түгээх талбай нь төв хэсэг, өндөр газар орших гэр

хороолол G- 1, нам газар орших гэр хороолол

G - 2, G - 3 гэсэн 4 хэсэгт хуваагдана (Зураг 8).

(2) Газрын доорхи усны нөөцийн ашиглалт

Харзатын усны эх үүсвэрийн нөөцийн ашиглалт

2015 оны хамгийн их усны хэрэгцээ нь 2140 м³/хон гэж тооцоологдсон. Нөгөө талаас одоогийн хамгийн их ус олзворлолт нь 1997 онд 1150 м³/хон байна. 2015 онд 990 м³/хон ус нэмж ашиглагдана.

2015 онд ашиглагдах нөөц

(нэгж : м³/хон)

	Үзүүлэлт	Нөөц
A	Ирээдүйд гаргах хамгийн их усны хэрэгцээ	2 140
B	Одоогийн нөхцөлд гаргах хамгийн их усны хэрэгцээ	1 150
C	Ирээдүйн ашиглалтын нэмэгдэх нөөц =(A - B)	990

Харзатны усны эх үүсвэрийн ашиглалтын төлөвлөгөө

Газар доорхи усны авч болох оновчтой хэмжээг Тейсийн тогтворжоогүй горимын тэгшитгэлийг ашиглан доорхи тоон утгуудад үндэслэн тооцоолов:

- уг талбайн дундаж түвшин дамжуулалт нь 360 м²/хон
- уст үеийн ус өгөмжийн коэффициент нь 0,005 (түрэлттэй ба түрэлтгүй усны горимоор)
- ус татах хугацаа 10 жил буюу 3650 хоног

2005, 2015 оны түвшний бууралтын тооцоог доорхи хүснэгтэд үзүүлэв. 3 худаг ажиллаж байхад 2005 оны усны хэрэгцээнд хангалттай. Тооцоолсон усны түвшингийн горимоор 2015 онд худгуудыг ашиглах нөхцөлд 4 худаг хангалттай. Гэвч энэ 4 худаг нь хуучирч муудсан. Иймээс цаашид одоо байгаа 4 худгийг 2015 оноос өмнө засварлан сайжруулж, шинэ нэг нөөц худгийг байгуулах нь зүйтэй.

2005 ба 2015 оны үед худгийн усны түвшин бууралтын тооцоо

Он	1997-98	2005	2015	* 2015	
Усны хэрэгцээ (дундаж)	960	1140	1500 м ³ /хон	2140 хамгийн их	
Худгийн тоо					
2	Шавхалтын ундарга м ³ /хон	480x2	570x2	750x2	1070x2
	Шавхалтын түвшний бууралт, м	-2,63	-3,12	-4,11	-5,87
	Нөлөөллийн түвшний бууралт, м	-1,17	-1,38	-1,82	-2,6
	Нийт түвшний бууралт, м	-3,80	-4,50	-5,93	-8,47
3	Шавхалтын ундарга м ³ /хон		380x3	500x3	714x3
	Шавхалтын түвшний бууралт, м		-2,08	-2,74	-3,91
	Нөлөөллийн түвшний бууралт, м		-0,92x2	-1,21x2	-1,73x2
	Нийт түвшний бууралт, м		-3,92	-5,16	-1,73x2
4	Шавхалтын ундарга м ³ /хон			375x4	535x4
	Шавхалтын түвшний бууралт, м			-2,06	-2,93
	Нөлөөллийн түвшний бууралт, м			-0,91x2- 0,79	-1,30x2-1 ,03
	Нийт түвшний бууралт, м			-4,67	-6,56
5	Шавхалтын ундарга м ³ /хон			300x5	428x5
	Шавхалтын түвшний бууралт, м			-1,64	-2,35
	Нөлөөллийн түвшний бууралт, м			-0,73x2- 0,64x2	-1,04x2+ 0,91x2
	Нийт түвшний бууралт, м			-4,38	-6,25

Худгийн байршил : шулуун шугамаар 100 м тутамд

* : (харьцуулж үзэх)

(3) Ус хангамжийн байгууламжийн хөгжлийн төлөвлөгөө

Хөгжлийн хувилбарууд

2015 оны усны хэрэгцээг хангах зорилгоор ус хангамжийн байгууламжийг хөгжүүлэх хэд хэдэн хувилбар байна. Хамгийн тохиромжтой хөгжлийн төлөвлөгөөг сонгох зорилгоор доорх хүснэгтэд ус түгээлтийн 3 гол аргыг үзүүлэв.

Хөгжлийн хувилбарууд

Нөхцөлүүд	Сүлжээний товч тайлбар	Түгээх байгууламж
1	Өндөр болон нам дор байрлах үйлчилгээний хэсгүүдэд тус тусад нь насосоор хүргэх.	Насос: 1,3 м ³ /минх35м х18 кватт х3ш 0,9 м ³ /мин х55 м х18 кватт х2ш Хоолой: диа.150-200 мм х9,3 км Бусад
2	Үйлчилгээний бүх хэсгүүдэд насосны дамжлагаар шууд хүргэх.	Насос: 1,8 м ³ /минх55мх30 кватт х3ш Хоолой: диа.150-200 мм 9,4 км Бусад
3	Нам хэстийн үйлчлүүлэгчдэд өөрийн даралтаар нь хүргэж өндөрт байрлах үйлчлүүлэгчдэд насосаар түгээх.	Насос: 1,5 м ³ /минх65мх30кваттх2ш Усан сан: 500м ² х2 сан Хоолой: диа.150-250х11,0 км Бусад

Байгаль орчны нөлөөлөл болон техник, санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүдээр ус хангамжийн байгууламжуудийг хөгжүүлэхэд илүү тохиромжтой нь 3-р нөхцөл юм.

Нөхцөлүүдийн шалгуур

Нөхцөлүүд	Техник	Байгаль орчин	Барилга байгууламжийн өртөг	Үйлчилгээний зардал	Санхүү	Илүү ашигтай нөхцөл
1	Дунд	Бага	Бага	Дунд	Дунд	2
2	Хүнд	Бага	Бага	Өндөр	Дунд	3
3	Хялбар	Бага	Бага	Бага	Бага	1

Усан хангамжийн байгууламжийн оновчтой хөгжлийн төлөвлөгөөг дараах байдлаар хийлээ.

Ус хангамжийн байгууламжийн хөгжлийн төлөвлөгөөнд 2015 онд шаардлагатай төхөөрөмжүүд

Арга хэмжээ	Барилга байгууламж
Байгаа байгуулам-	1, 4 худгийг засварлан сайжруулах (нөөц 1)

жуудыг сайжруулах	2, хяналтын систем бүхий гүний насостой мотор суурилуулах 0,42м ³ /мин х 60м х 4ш (нөөц 1)
Нэмэгдэл шинэ байгууламж	1, Усан санд усны түвшин заагч систем : 2ш 2, Ус зөөврийн машин нийлүүлэх : 3 машин 3, Ус зөөдөг тэрэг нийлүүлэх : 2792 (өрх)ш 4, Гэр хорооллын G - 1, G - 2, G - 3 хэсэгт түгээх гол шугам тавих : диа.150 - 200 мм х 11,0 км 5, Гэр хороололд ус түгээх байр барих : G - 1: 6 газар, G - 2: 3 газар, A - 3: 5 газар 6, Ус татах 1 худаг барих : одоо байгаа худгаас 100 м зайд 7, Дамжуулах шугам тавих : диа.200 мм х 3,5 км х 2 шугам 8, Шинэ усан сан барих : 500 м ³ х 2 сан 9, Шинэ насосны станц барих : 1,5м ³ /мин х 65 м х 2ш

3.4 ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

(1) Байгууллагыг бэжжүүлэх

Усны тариф

Усан хангамжийн үйлчилгээнд хамрагддаг хүмүүс нь хүрэлцээтэй хэмжээний, найдвартай усаар хангагдахын тулд усны үнийг нэмэн төлж чадна гэдгийг ЖАЙКА - гийн судалгааны хэсэг тодруулсан. Иймээс, усны тариф нь усан хангамжийн үйл ажиллагаа, менежментийн санхүүгийн байдлын үндсэн дээр тогтоогдох ёстой.

Хэмжүүрийн системийг суурилуулах

Хэрэглэгч болон ус хангамжийн байгууламжуудад хэмжүүр суурилуулах нь зайлшгүй шаардлагатай. Алтай хотын НААҮГ нь хэмжүүрүүдийг хянах, ус хэрэглээний төлбөрийг хураах ажлыг зохион байгуулах хэрэгтэй.

Ус алдагдлыг багасгах

Ус алдагдлын шалтгааныг тодруулж, түүнийг багасгахад чиглэсэн оновчтой арга хэмжээнүүдийг авч явуулах шаардлагатай. Крант, жорлонгоос алдах усны хэмжээг багасгах зорилгоор ус хэмнэх мэдлэгийг хүмүүст сургаж хэвшүүлэх нь чухал. Нөгөө талаас Алтай хотын НААҮГ шугамаас алдах ус алдагдлыг багасгах зорилгоор хуучирч муудсан түгээх шугамуудыг сайжруулах шаардлагатай.

Санхүүгийн хатуу менежментийг нэвтрүүлэх

Барилга байгууламж болон үйл ажиллагаа, засвар үйлчилгээг сайжруулах сэргээх хөрөнгө оруулалтын зардлыг бий болгосноор Алтай хотын НААҮГ өөрийн үйл ажиллагаагаа дээшлүүлнэ.

Зохион байгуулалт

Усны төлбөр хураах болон төрөл бүрийн тоног төхөөрөмжүүдийн хангамж, хяналтын хэлтсийн ажиллагсдын тоог нэмэгдүүлэх шаардлагатай болно.

Усны шугам сүлжээг гэр хороололд тавибал бохир усны хэмжээ нэмэгдэнэ. Энэ тохиолдолд бохирын системийг өргөжүүлэх хэрэгтэй юм.

(2) Хууль тогтоомжийг сайжруулах

Доорхи хууль зүйн үндэслэл бие даасан үйл ажиллагааг явуулахад зайлшгүй шаардлагатай.

1. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний стандарт гаргах.
2. Ус хангамжийн байгууллага нь Алтай хотын ЗДТГ - аас хамааралгүй бие даасан байх.

(3) Сургалтын систем

Механик болон электрон тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний гарын авлагыг бэлтгэж ажиллагсдыг засвар үйлчилгээнд сургах нь зайлшгүй шаардлагатай.

(4) Эрүүл ахуйн боловсролын төлөвлөгөө

Алтай хотын хүн амын эрүүл ахуйн боловсролыг сайжруулахад доорхи арга хэмжээнүүдийг зөвлөмж болгож байна.

Эрүүл ахуй ба ус хэрэглээний талаархи мэдлэгийг дээшлүүлэх

Чиглэх хэсэг: Алтай хотын бүх хүн ам.

Ашиглах хэрэгсэл: Орон нутгийн радио, телевиз.

Гарах үр дүн: Алтай хотын бүх хүн ам эрүүл ахуйн мэдлэгийг өдөр тутмын амьдралдаа нэвтрүүлнэ.

Хэрэгжүүлэх эзэн: Говь-Алтай аймгийн Нийгмийн эрүүл мэндийн төв/ЗДТГ.

Ус хадгалах болон ус хэрэглээний оновчтой менежмент

Чиглэх хэсэг: Гэр хорооллын оршин суугчид.

Ашиглах хэрэгсэл/Гүйцэтгэгчид: Эрүүл ахуйн сайн дурынхан.

Гарах үр дүн: Усыг зөв хадгалж, ус хэрэглээг нэмэгдүүлснээр уснаас гаралтай болон усаар дамжин халдварлах өвчлөлтүүд багасна.

Ус ба эрүүл мэнд

Чиглэх хэсэг: Сургуулийн хүүхдүүд.

Ашиглах хэрэгсэл: Сургуулийн анги танхим.

Гарах үр дүн: Эрүүл ахуйн суурь мэдлэгийг тэдгээрийн амьдралд хэвшүүлэх.

3.5 МОНИТОРИНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

(1) Газрын доорхи усны мониторинг

Газрын доорхи усаар хүмүүсийг тогтвортой хангах, түүний эдийн засгийн үйл ажиллагаа нь менежментийн хатуу хяналтын дор явагдах ёстой.

Доор дурьдсан одоо байгаа цэг болон ЖАЙКА -гийн зарим туршилтын цооног дээр газрын доорхи усны мониторингийг үргэлжлүүлэн явуулна.

В5 : Харзатын аллювийн уст үеийн эх үүсвэр
В6 : Олон нуурын аллювийн уст үеийн эх үүсвэр
А3 : Хадаасангийн ан цавын уст цогцолборын эх үүсвэр
А4 : Алтай хотын ВХ ан цавын уст цогцолборын эх үүсвэр

Доорхи үзүүлэлтүүдийг хэмжиж судалж байх ёстой.

- 1 Газрын доорхи усны түвшин
- 2 Ус зүйн болон цаг уурын мэдээ
- 3 Газрын доорхи усны чанар
- 4 Газрын доорхи ус ашиглалт
- 5 Мэдээллийн сан байгуулах
- 6 Газрын доорхи усны менежментийн төлөвлөгөө

Бүх мэдээ болон мэдээллийн сан нийтэд нээлттэй байх ёстой. Ингэснээр, хүмүүсийн ус хэмнэх, хүрээлэн буй орчныг хамгаалах, газрын доорхи ус нь хязгаарлагдмал нөөц гэсэн мэдлэгийг дээшлүүлнэ.

Газрын доорхи усны зөв ашиглалт, хамгаалалт нь зөвхөн төр засаг төдийгүй мөн хүмүүс, хэрэглэгчдийн хэрэг юм. Ингэлгүйгээр, газрын доорхи усны зүй зохистгүй ашиглалт, бохирдлыг хянах боломжгүй.

(2) Ус хангамжийн байгууламжинд хийх мониторинг

- татаж байгаа болон түгээх усны чанар
- шугамын төгсгөл дэх крантны усны үлдэгдэл хлор
- насосны станц дээр түгээх усны даралт
- шугамын төгсгөлд хангаж байгаа усны даралт

3.6 ЗАРДЫН ТООЦОО

Нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 3031060 ам.доллар бөгөөд үүнд барилгын ажил, газар ашиглалт, инженерийн байгууламжтай холбоотой зардал, болзошгүй зардал орсон болно.

Хөрөнгө оруулалтын зардал

нэгж ам.доллар

Ажлын үзүүлэлт	Тоо	Тоо хэмжээ		ОН	
				2000-2005	2006-2015
А. Барилга байгууламжийн шууд зардал		1,916,876		630,108	1,286,768
(1) Ус татах байгууламж		1,274,733	642,143	382,466	247,642
Байгаа хугаагүй сэрлэх	4 худаг	263,078		197,309	65,770
Шинэ худаг	1 худаг	230,547	32,531	172,910	24,398
		65,770			65,770
		57,637	8,132		57,637
(2) Ус даажуулах байгууламж					
Шинэ хоолой (диа.х200) х	3,5км	311,500		0	311,500
		245,000	66,500	0	0
(3) Түгээх байгууламж					
Усны түвшин хэмийгч					
Электрод	2 Ш	6,694		6,694	0
Даажуулах кабель	1 багц	6,586	108	6,586	108
		47,805		47,805	
Ус зөөврийн машин	3 машин	40,659	7,146	40,659	7,146
		52,800		52,800	
Усны тэрэг	2792 Ш	50,400	2,400	50,400	2,400
		92,136		92,136	
Ус түгээх байр	14 Ш	0	92,136	0	92,136
		71,484		51,060	20,424
Усан сан	2 цөөрөм	0	71,484	0	51,060
		78,140		0	78,140
		0	78,140	0	0
Шугам хоолой(диа.150)	11 км				
G-1 гар хороолол	(3,6км)	192,700		38,540	154,160
		128,260	64,440	25,652	12,888
G-2 гар хороолол	(1,3км)	67,500		51,975	15,525
		40,500	27,000	31,185	20,790
G-3 гар хороолол	(2,7км)	184,500		91,790	92,710
		110,700	73,800	55,074	36,716
Төвийн хэсэг	(3,4км)	186,520		0	186,520
		121,160	65,360	0	0
Насосны станц (насосыг оролцуул)	1	206,297		0	206,297
		157,714	48,583	0	0
Хлоржуулагч төхөөрөмж	1	53,250		0	53,250
		53,250	0	0	0
Усны түвшин хэмийгч	1 Ш	36,702		0	36,702
		32,320	4,382	0	0
В. Газар эзэмшлийн зардал		0		0	0
С. Барилга байгууламжийн зардал (АХ1,25)		2,396,095		787,635	1,608,460
Д. Зураг төсөл, удирдлагын (СХ0,1)		239,610		78,764	160,846
Нарийвчилсан зураг төсөл (СХ0,1)		119,805		39,382	80,423
Удирдлагын (СХ0,005)		119,805		39,382	80,423
Е. Байгалийн гамшиг ((С+D) X 0.15)		395,356		129,960	265,396
Бүгд (С+D+E)		3,031,060		996,359	2,034,702

Жин: 1) 1ам.доллар= 117,5иен 1 ам.доллар= 890төг

①	②	③
---	---	---

1. Бүгд 2. Гадаад 3. дотоод

3.7 ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Усны эх үүсвэр болон ус хангамжийн байгууламжийг сайжруулах, өргөжүүлэх ажил нь доорхи хүснэгтэнд үзүүлсэн хөтөлбөрийн хэрэгжүүлэлтийн үндсэн дээр алхам алхамаар хэрэгжих болно.

Хэрэгжүүлэх хуваарь

Ажлын үзүүлэлт	Тоо хэмжээ	2000 - 2015 он															
		2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
(1) Ус татах байгууламж																	
Байгаа худгуудыг сэргээх (Гүний насостой)	4 худаг																
Шинэ худаг байгуулах (Гүний насостой)	1худаг																
(2) Дамжуулах байгууламж																	
Шинэ шугам хоолой (диа.200 x 2шугам)	3,5 км																
(3) Түгээх байгууламж																	
Усны түвшин хэмжигч	2 Ш																
Усны машин	3 машин																
Усны тэрэг	2792ш																
Ус түгээх байр	14 байр																
G-1 Гэр хороолол	(6)				(2)					(4)							
G-2 Гэр хороолол	(3)				(3)												
G-3 Гэр хороолол	(5)					(5)											
Усан сан	2 сан																
Шугам хоолой (диа.150-250)	11км																
G-1 гэр хороолол (диа.150-200)	(3,6)				(0,7)					(2,9)							
G-2 гэр хороолол (диа.150)	(1,3)				(1,0)												(0,3)
G-3 гэр хороолол (диа.150)	(3,7)					(1,8)									(1,2)	(0,7)	
Төвийн хэсэг (диа.150-250)	(3,4)									(2,0)	(0,8)	(0,6)					
Насосны станц (насосыг оролцуулан)	1 станц																
Хлоржуулагч төхөөрөмж	1 Ш																
Усны түвшин хэмжигч	1 ш																

3.8 АРИУН ЦЭВРИЙГ САЙЖРУУЛАХ ХӨТӨЛБӨР

2005, 2015 онд усан хангамжийн байгууламжийг өргөжүүлэх нөхцөлд ундны усны эх үүсвэрийг хамгаалах доор дурьдсан ариун цэврийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

-Төвийн орон сууцанд : хаягдал, бохир усыг цэвэрлэхбайгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх.

-Гэр холоололд : хувийн болон хорооны цэвэрлэх байгууламжийг байгуулах.

3.9 МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨНД ТӨСЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ

(1) Эдийн засгийн дүн шинжилгээ

Үр дүнг доорхи хүснэгтэд нэгтгэн үзүүлэв.

Мастер төлөвлөгөөний эдийн засгийн үнэлгээний үр дүн

Нөхцөл	EIRR (%)	B/C	NPV (\$)
Стандарт	14,5	1,23	591 000
Өртөг 10 % иас дээш (A)	12,4	1,12	339 000
Ашиг 10 % иас доош (B)	12,2	1,11	280 000
(A) + (B)	10,3	1,01	29 000

EIRR - эдийн засгийн эргэлтийн дотоод түвшин

B/C - ашиг өртөгийн харьцаа (ашигт ажиллагааны түвшин)

NPV - одоогийн жинхэнэ өртөг

Эдийн засгийн эргэлтийн дотоод түвшин нь стандарт нөхцөлд 14,5% байгаа нь мастер төлөвлөгөөнд эдийн засгийн эргэлт өндөр байгааг заах ба хөрөнгө буюу эдийн засгийн эргэлтийн дотоод түвшингийн алдагдлын өртөгтэй харьцуулагдана.

Эдийн засгийн үнэлгээг доор дурьдсан нөхцөлд үндэслэн явууллаа.

- 1) Шугам сүлжээний ашиглалтын хугацааг 25 жил гэдэг дээр үндэслэн эдийн засгийн дүн шинжилгээний хугацааг тогтоов.
- 2) Зардалд хөрөнгө оруулалт, засвар үйлчилгээ, шинэчлэлтийн зардлыг оруулна. Стандартын

өөрчлөлтийн фактор нь 1,0 байхад тооцоолсон зардлыг хянаж үзэхгүй. Тооцоолсон зардал нь:

Хөрөнгө оруулалт : нийт 3 031 мян.ам.доллар

Засвар үйлчилгээ : 2015 он түүнээс цааш жилд
82 мян.ам.доллар

Шинэчлэлт : нийт 1 593 мян.ам.доллар

- 3) Ус хангамжийн эдийн засгийн ашгийг усны ертөг өндөр байгаа болон хэрэглэгчдийн төлбөрийн чадварт үндэслэн тооцлоо. Усны хэрэгцээ нь хамгийн бага байгаа болон нөгөө талаар ус нь таваар гэсэн 2 хэсэгт хуваагдана. Доорхи хүснэгтэд ашигласан тоо болон эдийн засгийн ашгийн тооцоог үзүүлэв.

Ус хангамжийн эдийн засгийн ашиг

Үзүүлэлт	Нэгж	Хамгийн бага хэрэгцээ	Таваар
Хэмжээ	Төг/м ³	1 875	67
	Ам.дол/м ³	2,11	0,08
2015 оны ус хэрэглээ			
Орон сууц	л/хон	20	130
Гэр хороолол	л/хон	20	1,2
2015 оны хүн амын тоо			
